

# ОРОН ЗАЙН ӨГӨГДЛИЙН ДЭД БҮТЦИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Улаанбаатар хот

2020.02.20

## 1 Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын Дэд бүтцийн салбарыг хөгжүүлэх 5 дугаар зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээнд “...үндэсний орон зайн мэдээллийн дэд бүтцийг байгуулах...” гэж, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор батлагдсан “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 2.80.5-д “Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн төслийг боловсруулна.” гэж, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 47 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого /2017-2025/-ын баримт бичиг”-ийн 3.4.8-д “гео-орон зайн мэдээллийн дэд бүтцийг ашиглан төрийн байгууллага, иргэдэд үнэн зөв, нарийвчлалтай мэдээлэлд үндэслэсэн орон зайн дүн шинжилгээ, ухаалаг төлөвлөлт хийх боломжийг бүрдүүлнэ.” Монгол Улсын Их Хурлын 2019 оны 54 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн “3.Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлого”-ын Байгалийн нөөц баялаг, дэд бүтцийн онцлогт тулгуурлан хүн амын нутагшил, суурьшил, хот суурины оновчтой тогтолцоог бий болгож, иргэдийн аюулгүй ая тухтай амьдрах орчныг бүрдүүлэх 8 дугаар зорилтын 8.3 “Орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэгч байгууллагуудын санг геопорталаар дамжуулан цахимжуулж, хэрэглээнд нэвтрүүлэх.”, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 70 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого”-ын “2.2.8. барилгын салбарыг хөгжүүлэх зорилт, арга хэмжээг үндэсний орон зайн мэдээллийн дэд бүтцэд тулгуурлан газрын харилцааны бодлого, төлөвлөлттэй уялдуулан хэрэгжүүлэх.” гэж тус тус заасны дагуу орон зайд суурилсан өгөгдөл мэдээллийг бүрдүүлэх, боловсруулах, хадгалах, хамгаалах, түгээх, хэрэглэх түвшний эрх зүйн харилцааг зохицуулсан Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн төслийг боловсрууллаа.

## 2 Практик шаардлага

### 2.1 Орон зайн өгөгдлийн хэрэглээ

Өнөөдөр Монгол улсад орон зайн өгөгдлийн санг бүрдүүлэх, ашиглах асуудлыг зохицуулсан хүчин төгөлдөр үйлчилж буй 13 хуульд давхардсан тоогоор 44 мэдээллийн сан<sup>1</sup>-ийн талаар тодорхой зохицуулалт байгаа боловч сангуудын хоорондын уялдааг хангах, орон зайд дүрслэгдэх өгөгдөл, мэдээллийн нэгдсэн системийг бий болгох, орон зайн өгөгдлийн нэгдмэл байдлыг хангахтай холбоотой эрх зүйн зохицуулалт байхгүй байна. Үүний улмаас орон зайн өгөгдлийн сан /газар зүйн мэдээллийн сан/-г яам, агентлаг, байгууллага, төслийн нэгж бүр өөр өөрсдийн түвшинд, янз бүрийн аргаар байгуулсаар ирсэн. Жишээлбэл:

- Байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй яам, Усны газар, Ойн газар, Ус, цаг уур, орчны шинжилгээний газрын харьяа мэдээлэл, тооцооллын төв, байгаль хамгаалах олон улсын төслүүд /нэлээд олон төсөл бий/;

<sup>1</sup> Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн төслийг боловсруулах, хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах үнэлгээний тайлангаас

- Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй яам, газар, олон улсын төслүүд;
- Эрчим хүч, эрдэс баялгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй яам, Ашигт малтмалын газар, Газрын тосны газар, мэдээллийн төв, Дэлхийн банкны төсөл;
- Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй яам, замын газар, тээврийн газар, Газрын харилцаа, барилга, геодези, зураг зүйн газар /Үндэсний газрын мэдээллийн систем/, олон улсын төслүүд;
- Нийслэлийн захирагчийн албаны холбогдох газар, албад /Барилга, хот байгуулалтын алба, Газрын алба / г.м

Эдгээрийн уялдаа, холбоог хангахад нэгдсэн стандартын дагуу бүрдүүлж, ашигласнаар төсвийн давхардал, мэдээллийн шинэлэг, баталгаатай байдал хангагдах юм.

## **2.2 Нээлттэй орон зайн өгөгдлийн сангийн хэрэглээ**

### **2.2.1 Иргэдийн хэрэгцээ**

Хотын хүн амын өсөлтийг хэрхэн төлөвлөж шийдвэрлэх вэ?, Агаарын бохирдол юунаас болж байна вэ?, Хэдэн гол, мөрөн, нуур эсвэл хэдэн хувь нь устаж үгүй болж байна вэ? Сургууль, цэцэрлэг, ясли, дэлгүүр, автобусны буудалд ойрхон, үйлдвэрийн утаанаас зайтай байр, хашаа хаана байна вэ?, Ард Аюушийн 10-р гудамж хаанаас эхлээд хаана дуусдаг юм бол? Багахангай дүүрэг хаана байдаг вэ?, аль аймгийн ямар сумдтай хиллэдэг юм бэ? гэх мэт асуултын хариуг иргэн хүн өөрийн ая тухтай орчинд амьдрах, сурч боловсрох, мэдээлэл олж авах үндсэн эрхийнхээ хүрээнд төрийн үйлчилгээгээр дамжуулан авах хүсэлтэй байдаг боловч төр шинэлэг, баталгаат мэдээллээр хангах боломж хомс байдаг. Үүний улмаас иргэд нэгнээсээ асуух, интернэтээс хайх, Google Earth, Openstreetmap газрын зураг гэх мэт тодорхойгүй, гадны эх сурвалжаас мэдээлэл авч байна.


### **2.2.2 Ухаалаг хот, бизнесийн орчин**

Ухаалаг хотыг тодорхойлогч нэг хүчин зүйл нь аюулгүй, түгжрэлгүй, эдийн засгийн хэмнэлттэй замчлах системийн хэрэглээ буюу байрлалд суурилсан замчлах систем /roadmap/ юм. Манай улсын хот суурин газруудын суурь орон зайн өгөгдлийн баталгаатай, нээлттэй байдал хангалтгүй байгаагаас дэлхийн байрлал тодорхойлох тогтолцоо (GPS)-ны болон авто замын навигацийн, байрлалд суурилсан төрөл бүрийн хайлтын, онлайн бүтээгдэхүүн үйлчилгээ /автомашин газрын зураг, бараа, бэлэн хоол хүргэлтийн үйлчилгээ, шуудан /-ний хязгаарлагдмал, ухаалаг хотыг дэмжсэн бизнесийн орчин бүрдэхгүй байна.

## **2.3 Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн хэрэглээ**

Мэдээллийн технологийн хөгжил нэмэгдэхийн хэрээр их өгөгдөл /big data/, нээлттэй өгөгдөл /open data/, геопортал зэрэг их хэмжээний мэдээлэл агуулсан дэд бүтцийг бий болгох боломжтой болсон. Шийдвэр гаргах түвшинд орон зайн өгөгдлийн дэд бүтцийг ашиглах нь давхардсан зардлыг бууруулах, оновчтой хөрөнгө оруулалт хийх, алдаагүй бодлого гаргах боломжийг бүрдүүлдэг. Дэлхийн банкнаас 2019 онд Монгол улсад хийсэн судалгаа<sup>2</sup>-нд дурдсанаар манай улс орон зайн өгөгдлийн дэд бүтэц байгуулан ашиглавал эхний 2 жилд орлого зарлагаасаа бага түүнээс цааш 10 жилийн хугацаанд 2.6 дахин их үр ашиг хүртэнэ гэсэн дүгнэлтийг хийсэн.

<sup>2</sup> “Үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтцийн Монгол Улсын нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөллийн шинжилгээ” тайлан



*Зураг 1 Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үр ашгийг валютаар үнэлсэн байдал, /WB, 2019/*

## 2.4 Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн нийгэм, эдийн засагт үзүүлэх шууд ба шууд бус дэмжлэг

Орон зайн өгөгдлийн дэд бүтцээр дамжуулан байрлалд суурилсан дүн шинжилгээг ашигласнаар цахим засаглал бэхжих бөгөөд салбаруудын үйл ажиллагаанд дараах байдлаар эдийн засгийн шууд ба шууд бус дэмжлэгийг үзүүлнэ.

Газрын харилцаа:

- Газрын бүртгэлийн цэгцтэй, ил тод, баталгаат байдал хангагдах;
- Газраас улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээ бодитой, газрын татвар, төлбөрийн харилцааг зохицуулах цахим орчин бүрдэх;
- Газар чөлөөлөхтэй холбогдсон нөхөх олговрын хэмжээг бууруулах.

Хот байгуулалт, стратегийн төлөвлөлт:

- Хаягийн систем илүү боловсронгуй болж, иргэн хуулийн этгээдэд цаг хугацаа, эдийн засгийн хэмнэлт бий болох;
- Статистик мэдээлэлд орон зайн дүн шинжилгээ хийж, шийдвэр гаргах;
- Төвлөрлийг сааруулах ухаалаг төлөвлөлт хийх.

Тээвэр:

- Цаг хугацаа, зардал хэмнэсэн логистик байгуулах;
- Хөдөлгөөний ачаалалтай уялдсан тооцоолол хийх;
- Тээврийн аюулгүй байдал хангагдах;
- Авто зогсоолын ашиглалтыг сайжруулах.

Эрүүл мэнд, яаралтай тусламж:

- Байгаль орчин, экологид учрах хохирлыг бууруулах;
- Ослын үед цагдаа, гал түймэр, эмнэлгийн үйлчилгээг хурдан хүргэх;
- Гэмт хэргийн шалтгаан нөхцөл байдлыг шуурхай тодорхойлох;
- Мал, амьтны халдварт өвчний тархалт, сэргийлэх арга хэмжээг оновчтой тодорхойлох.

Уул уурхай, эрдэс баялаг:

- Хайгуул, судалгаанд зарцуулах хөрөнгийг бууруулах;
- Ашигт малтмалын лицензийн давхардалтай холбогдсон салбар хоорондын маргааныг арилгах;

- Хайгуул, ашиглалтын ажлын төлөвлөлт, хяналтыг сайжруулах.

Хөдөө аж ахуй:

- Бэлчээрийн даац, газрын доройтлоос зайлсхийх, урьдчилан таамаглах;
- Малын эрүүл мэндийг хамгаалах ажлыг илүү үр дүнтэй зохион байгуулах;
- Тариалалтыг байгаль цаг уурын нөхцөлтэй уялдуулан үр ашигтай төлөвлөх;
- Ургамлын болцыг бүсчилсэн байдлаар нарийвчлан тодорхойлох.

Инженерийн дэд бүтэц:

- Сэргээгдэх эрчим хүчний нөөцийн төлөвлөлт, үр ашгийг оновчтой тооцох;
- Төвлөрсөн системийн ачаалал, алдагдалд дүн шинжилгээ хийх боломж бүрдүүлэх;
- Хотын инженерийн шугам сүлжээний хангамж шаардлагатай хэсгийг тодорхойлох.

Бизнес эрхлэх:

- Жижиглэнгийн худалдааг хэмнэлттэй үр ашигтай зохион байгуулах, хэрэглэгчдэд илүү ойртох боломжтой болгох;
- Банк, санхүүгийн үйлчилгээг шаардлагатай газарт шуурхай хүргэх;
- Үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн оролцогчдыг байрлалаар нь ойртуулах, ашигтай худалдан авах хийх.

### 3 Гадаад орнуудын эрх зүйн орчны талаар

АНУ-д Ерөнхийлөгчийн зохион байгуулалт ба төсвийн газраас орон зайн мэдээллийн үйл ажиллагааг зохицуулахаар Холбооны газар зүйн мэдээллийн хороог 1994 онд байгуулан стратегийн төлөвлөгөө боловсруулан хамтран ажиллах, оролцох байгууллагуудыг нарийн тогтоосон байдаг. Холбооны газар зүйн мэдээллийн хорооноос 2018 оноос эхлэн Орон зайн мэдээллийн тухай хуулийн төслийг боловсруулж 2019 онд конгресстоо өргөн барьсан.

ӨАБНУ, Канад, Энэтхэг, БНСУ зэрэг улсуудад Орон зайн мэдээллийн хууль батлагдаж Үндэсний хороо байгуулан ажиллаж байна.

БНСУ-д 2000 онд Үндэсний газар зүйн мэдээллийн системийн хууль, ҮГМС-ийн хуулийг хэрэгжүүлэх Ерөнхийлөгчийн тогтоол батлагдан, 1995 оноос тав, таван жилээр мастер төлөвлөгөө боловсруулан одоо 5 дахь таван жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлж байгаа бөгөөд үүний үр дүнд БНСУ нь дэлхийд дээгүүр тооцогдох Орон зайн мэдээллийн санг буй болгон ердийн иргэд ч түүнийг гар утсаараа дамжуулан, өөрсдийн машинд суурилуулсан GPS-ийн навигацийг орон зайн мэдээллийн сантай хамтатган ашиг шимийг нь хүртэж байна.

### 4 Хуулийн төслийн бүтэц

#### 4.1 Хуулийн төсөл нь 6 бүлэг, 20 зүйлтэй:

- Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл
- Хоёрдугаар бүлэг. Орон зайн өгөгдлийн төрөл, дүрслэл, тэдгээрийн бүрдэл
- Гуравдугаар бүлэг. Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагаа
- Дөрөвдүгээр бүлэг. Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт
- Тавдугаар бүлэг. Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн улсын хяналт
- Зургаадугаар бүлэг. Бусад

**Нэгдүгээр бүлэгт:** Хуулийн зорилт, үйлчлэх хүрээг тодорхойлж, орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагаанд баримтлах зарчим, зарчмыг хэрэгжүүлэх арга, нэр томъёоны тодорхойлолтыг тусгасан.

**Хоёрдугаар бүлэгт:** Орон зайн өгөгдлийг төрөл, түүнд хамаарах өгөгдлийн жагсаалтыг тодорхойлсон. Ингэхдээ суурь орон зайн өгөгдлийн бүрэлдэхүүн мэдээллүүдийг өнөөгийн нөхцөл байдал, олон улсын түвшинтэй харьцуулан гаргасан. Мөн өгөгдлийн тухай мэдээлэл буюу мета-дата бүрдлийн тухай, мэдээллийг ашиглах эрхийн төрлийг тусгасан.

**Гуравдугаар бүлэгт:** Өгөгдөл бүрдүүлэх, боловсруулах, хадгалах, хамгаалах, түгээх, хэрэглэхтэй холбогдсон техникийн зохицуулалт, тэдгээрт тавигдах шаардлагыг тодорхойлсон. Геоплатформыг бүрдүүлэгч, хэрэглэгч талуудын хоорондох эрхзүйн харилцаа, орон зайн суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээг дэмжих эрх зүйн зохицуулалт, нээлттэй ба хаалттай өгөгдлийн зохистой харьцааг нарийвчлан тусгалаа.

**Дөрөвдүгээр бүлэг:** Орон зайн өгөгдлийн дэд бүтцийг улсын хэмжээнд хэрхэн удирдах, засгийн газрын дэргэд ажиллах орон тооны бус хорооны эрх үүрэг, байгууллага, хувийн хэвшлийн оролцоо, хүлээх үүргийн талаар тусгасан. Мөн тусгай зөвшөөрлийн эрх зүйн орчныг бүрдүүлэх, санхүүжилт, орлого бүрдүүлэлт, зарцуулалтын эрх зүйн орчныг тодорхойллоо.

**Тавдугаар бүлэгт:** Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн улсын хяналт, түүнийг хэрэгжүүлэх этгээдийн эрх зүйн байдлыг тогтоосон.

**Зургаадугаар бүлэгт:** Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох хугацааг заасан.

#### **4.2 Дагалдах хуулийн төсөл**

Мөн энэхүү хууль батлагдсаны дараа бэлтгэл ажлыг хангах, бусад хуульд нэмэлт өөрчлөлт оруулахаар дараах хуулийн төслүүдийг боловсруулсан. Үүнд:

- Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай
- Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай
- Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт оруулах тухай
- Хаягжуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

---oOo---